



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 08 сарын 22 өдөр

Дугаар А/304

Улаанбаатар хот

**Ёс зүйн зөвлөлийг шинэчлэн  
байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дах хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2 дах хэсэг, Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоол, “Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын дүрэм”-ийн 2.4-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын дэргэдэх Ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, “Ёс зүйн зөвлөлийн ажиллах журам”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. “Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг нийт албан хаагчдад чанд мөрдүүлэн, зөвлөлийн ажлын төлөвлөгөө, тайлан, дүгнэлтийг цаг тухайд нь танилцуулан, холбогдох байгууллагад мэдээлж ажиллахыг Ёс зүйн зөвлөл /Д.Төмөрбаатар/-д даалгасугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан газрын даргын 2019 оны А/35 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ

Тушаал-2019

115050000847